

АМЬД
УЛДЭХИЙГ
ХҮССЭН

ХҮҮН

СТИВЕН
КИНГ

Амьд үлдэхийг хүссэн хүн

Стивен Кинг

Survivor Type

Stephen King

Өвчтөн хэр хүчтэй гэмтлийн шокийг даах боломжтой вэ? Энэ бол анагаахын оюутан болгоны өмнө эрт оройгүй заавал тулгардаг асуулт юм. Энэ асуултанд багш болгон янз бүрээр хариулдаг ч гол төлөв “Өвчтөн тэсч гарахыг хэр их х үсч байна вэ?” гэсэн өөр нэг асуултаар хариулдаг.

1-р сарын 26

Далайн давалгаа намайг энэ эрэг дээр гаргаж хаяснаас хойш хоёр өдөр өнгөрлөө. Өнөө өглөө би арлыг бүхэлд нь тойрч үзсэн. Арал ч гэж дээ... Хамгийн өргөн газраа зуун ерэн алхам, нэг үзүүрээсээ нөгөө үзүүр хүртлээ хоёр зуун жаран долоон алхам урт.

Надад харагдсанаар бол энд идчихэж болох зүйл огт алга.

Намайг Ричард Пайн гэвэг. Харин энэ бол миний өдрийн тэмдэглэл. Намайг эндээс оллоо / хэзээг нь бүү мэд/ гэж бодоход тэмдэглэлээ хялбархан устгачихаж чадна. Чүдэнзнээс их юм алга. Чүдэнз бас героиноос их юм алга. Юу л байна энэ хоёр л байна. Аль алиных нь төлөө амиа золиослон байж энд ирэх хэрэггүй байж дээ, ха ха. За ингээд ямар ч байсан би тэмдэглэл хөтлөх болно. Их бага ямар нэг хэмжээгээр цаг нөхцөөхөд тус болох байх.

Нэгэнт л бүгдийг, бүгдийг гэснээс яагаад болохгүй гэж гэж? Надад юу л байна цаг зав байгаа болохоор бүгдийг бичихээр шийдсэн болохоор би бол Нью-Йоркийн Бяцхан Италид төрсөн Ричард Пинцетти байна гэдгээс эхлэх хэрэгтэй. Эцэг маань Европоос ирсэн. Би мэс засалч болохыг хүсдэг байлаа. Харин эцэг болохоор намайг шоолж, солиотой амьтан гэж дуудчихаад ахиад нэг стакан дарс аваад ир гэдэг байлаа. Тэрээр дөчин зургаатай байхдаа хорт хавдраар нас барсан юм. Би ч ингэсэнд нь баярлсан шүү.

Сургуульд байхдаа америк хөл бөмбөг тоглодог байлаа. Би чинь сургуулийнхаа түүхэнд гарч байсан хамгийн шилдэг хөл бөмбөгчин байлаа. Хамгаалагч. Сүүлийн хоёр жилд нь хотын шигшээд тоглосон. Би уг нь хөл бөмбөгийг үзэн яддаг байсан. Гэхдээ чи итали гаралтай, дээр нь коллежд сурахыг хүсч байгаа бол цорын ганц боломж нь спорт байдаг хойно яая гэхэв. Тэгээд л би тоглож, спортын боловсрол олж авч байлаа.

Коллежд үе тэнгийхэн минь академик боловсрол авч байхад би хөл бөмбөг тоглож байлаа. Ирээдүйн эмч шүү. Төгсөхөөс зургаан долоо хоногийн өмнө эцэг маань нас барсан юм. Ёстой сайхан байсан шүү. Тайзан дээр дипломоо авахаар гарчихаад тэр муу бүдүүн гахайг сууж байгааг харахыг хүсдэг байсан гэж та нар арай бодоогүй биз дээ? Таны бодлоор загасанд борооны цув хэрэгтэй юу? Би оюутны нэгэн байгууллагад элсэж орлоо. Пинцетти чиг гэх шиг овогтой над мэтийн хүнийг элсүүлж байсан болохоор тийм ч сайн байгууллага биш нь ойлгомжтой ч оргүйгээс...

Би яагаад энэ бүгдийг бичээд байгаа юм бол? Миний амьдралд болж өнгөрсөн бүхэн бараг л зугаатай гэмээр юм даа. Үгүй ээ, биш. Үнэхээр, жинхэнэ зугаатай. Аугаа их эмч Пайн гуай унтлагын хувцасны өмд, богино ханцуйтай цамц өмсөчихсөн арал дээр, алгын чинээ умгар, эзгүй арал дээр суучихаад өөрийнхөө түүхийг бичиж байна. Өлсөж байна шүү. Гэхдээ, энэ хамаагүй ээ. Нэгэнт л хүссэн болохоор балай түүхээ бичих л болно. Идэх юмны тухай бодлоос сатаарахад тус болж л таараа.

Би эмнэлгийн коллежд орохоосоо өмнө овгоо Пайн болгоод өөрчилчихсэн юм. Тэгсэн чинь зүрхийг нь зүссэн юм хийлээ ч гэх шиг эх гуай үглээд л байсан. Ямар зүрхнийхэ тухай ярьж байсан юм бол доо? Өвгөнийг хадан гэр рүүгээс явсны маргааш нь шахуу л гудамжны адагт

байдаг хүнсний дэлгүүрийн эзэн еврей эрийг хоргоогоод гүйж байсан юм даг. Овгоо дээдэлдэг дээдэлдэг гэхэд Штейбургер болгон солих гэж эх гуай арай л дэндүү яарчихсан юм.

Миний цорын ганц мөрөөдөл бол мэс засал байлаа. Сургуульд байхаасаа л мөрөөддөг байсан. Тийм болохоор тэр үеэс л би тоглолтын өмнө үргэлж бээлийн өмсөж, дууссаных нь дараа гараа дэвтээдэг байсан юм. Үүнээс болж зарим хөвгүүд намайг дэгдээхэйний сангас гэж дооглоно. Тэглээ гээд би тэдэнтэй хэзээ ч зодолдож байгаагүй. Хөл бөмбөг тоглоно гэдэг тэртээ тэргүй асар их эрсдэл. Гэхдээ надад өөр бас бус арга байлаа. Хоу Плоцки гэдэг батга царайлсан, том биетэй, мангар юм намайг хамгийн их өддөг байлаа. Би бага зэрэг мөнгөтэй. Ганц хоёр хүн таньдаг, тав гурван үг сольдог байсан. Гудамжинд ингэлгүйгээр хол явахгүй шүү. Яавал үхэхээ захын тэнэг л мэднэ. Тэгэхээр яаж амьд гарав вэ гэдэгт л асуудлын гол нь байдаг юм. Ойлгож байгаа биз дээ. Тэгээд яахав манай сургуулийн хамгийн том биетэй залуу Рикки Браццитай уулзаад Хоу Плоцкийн амыг нь таглаад өг гээд мөнгө төлсөн, арван доллар. Дээр нь цөм цохиод авчирч өгсөн шүд болгоныг нь тус бүр нэг доллараар худалдаж авна гэж хэлсэн юм. Рикки надад цаасанд боочихсон гурван шүд авчирсан даа. Хоуг эд бад хийж байхдаа Рикки хоёр ч хурууныхаа ясыг гэмтээсэн байсан болохоор энэ ажил миний гар хуруунд ямар их аюултай байсан нь ойлгомжтой болж байгаа байх.

Анагаахын коллежид гоожуурууд хувцасны тамтаг өмсчихөөд кафенд зөөгч хийж, гудамжинд зангиа зарж, шал угаангаа завсар зайгаар нь хичээлээ цээжлэх гэж үйлээ үзэж байхад би тун ч дажгүй амьдардаг байлаа. Хөл бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээний бооцоо, мөрийтэй тоглоом. Хуучин найз нартайгаа харьцаагаа таслаагүй байсан хэрэг. Тийм ч болохоор коллежид муугүй байсан.

Гэхдээ л дадлагад гарснаараа ёстой нэг жаргасан даа. Нью-Йоркийн хамгийн том эмнэлгүүдийн нэгэнд ажилладаг байсан юм. Анхандаа бол зөвхөн эмийн хоосон жор дээр ажилладаг байлаа. Найз нарынхаа нэгэнд нь зуун ширхэг хоосон жор зарна, тэр надаас аваад дөч тавин эмчийн гарын үсгийг дуурайлгаж зурна. Дуурайлгаж зурах эхийг нь бас л надаас худалдаж авна. Тэгээд дараа нь гарын үсэгтэй жороо гудамжинд нэг бүрийг нь арав, хорин доллараар зардаг. Тийм жор худалдаж авах гэсэн малууд захаас авахуулаад л мундахгүй.

Тун удалгүй эм, бэлдмэлийн агуулах маш муу хараа хяналттай байдгийг олж мэдлээ. Агуулахад хэр их эм бэлдмэл орж, гарч байдгийг хэн ч сайн мэддэггүй. Хар тамхийг шуудайлах нь шахуу аваад гардаг хүмүүс ч байсан. Би бол тэгдэггүй. Угийн л болгоомжтой хүн. Хэзээ ч гэнэдэж, гарцаагүй байдалд орж байгаагүй хүн дээ би. Хэт тайвширч, азын тэнгэр нүүр буруулах хүртэл л дээ. Гэхдээ зүгээрээ, эргээд сэхэх цаг ирнэ. Үргэлж л сэхэж байсан юм чинь.

Харин одоо ахиад бичиж чадахгүй нь. Гар чилж, харандаа мохчихлоо. Яагаад түгшээд байгаагаа мэдэхгүй юм. Удалгүй намайг эндээс олж авах байх.

1–р сарын 27

Завийг өчигдөр урсгалаар аваад явчихаж. Арлын хойд хэсгээс арван футын зайтай живчихсэн байна. Трос хаанаас олох вэ? Тэнгисийн цохио мөргөчихсөн болохоор завьны ёроол нь швейцар бяслаг шиг бөөн цоорхотой болчихсон байгаа. Дээр нь байсан хэрэгтэй гэсэн болгоноо би авчихсан байсан юм. Дөрвөн галлон цэвэр ус. Оёдлын иж бүрдэл. Эмийн сан. Уг нь бол хөлгийн бүртгэл хөтлөх ёстой байсан дэвтрийг авсан нь одоо ингээд миний өдрийн тэмдэглэл болчихоод байж байна. Хачирхалтай юм гэж бас байх юм даа. Дотроо хүний урманд ганц грамм ч хүнсгүй аврах завь гэж бас байдаг гэнэ ээ. Энэ хөлгийн бүртгэлийн дэвтр дээр 1970 оны 8–р сарын 8–нд хамгийн сүүлд тэмдэглэл хийжээ. Аан, тийм бас нэг мохой, нэг маш иртэй хутга, эвхэгддэг халбаг сэрээ. Өнөө орой хоол идэхэд хэрэг болно доо. Хоол нь шарсан хад. Ха ха. За за, ямар ч байсан харандаагаа үзүүрлэчихлээ.

Шувууны сангасанд дарагдсан энэ хадан дээрээс мултрахаараа хамгийн эхэнд тээврийн компанитай учраа ололцож шүүхэд өгнө дөө. Үгүй ядаж зөвхөн үүний төлөө л амь явсан ч болохоор шүү дээ. Харин би бол амьд явна гэж бодож байгаа. Эндээс мултарна гэж бодож байгаа. Тэгэхээр намайг хялбархаан буюгаад өгчихөнө гэж бүү горьд. Эндээс мултарна даа. / хэсэг хугацааны дараа/ Завин дээрээс авсан юмныхаа жагсаалтыг гаргаж байхдаа нью–йоркийн гудамжны үнээр гурван зуун тавин мянган орчим долларын үнэтэй хоёр килограмм дээд зэргийн героиныхаа тухай бичихээ мартчихаж. Харин энд бол сохор зоосны ч үнэ хүрэхгүй. Инээдтэй байгаа биз. Ха ха.

1–р сарын 28

Ямар ч л байсан хооллочихлоо. Хоол ч гэж дээ. Арлын төв хэсгийн нэг хадан дээр цахлай суучихсан юм. Тэр хэсгийн хад, асга нь замбараагүй овоороод, сангасанд битүү хучигдсан нуруурхуу юм үүсгэдэг. Би тэндэс гарт эвтэй чулуу олж байгаад зоригоо хүрэх газар цахлайнд гэтэж очлоо. Цахлай хадан дээр суучихаад гялалзсан хар нүдээрээ намай ширтэж байсан. Миний гэдэсний хуржигнан дуугарах чимээнээс үргээд нисчихээгүй нь сонин.

Чулуугаа чадал мэдэн шидсэн чинь бөөрөнд нь оночиховоо. Цахлай чанга орилоод нисэх гэж оролдсон ч би баруун далавчийг нь хугалчихсан. Тэгээд тэр надаас зугатаад, би араас нь хөөж эхэлсэн. Цус нь цав цагаан өдийг нь даган урсаж байгаа би харж байсан шүү. Чөтгөрийн шувуу чинь миний үйлийг нэлээд үзсэн. Төв хадны нөгөө талд нь гарч яваад хөлөө хоёр чулуун завсар хавчуулаад золтой л шагайгаа хугалчихаагүй.

Тэгэж тэгэж цахлайг цуцахаар нь арлын зүүн хэсэгт гүйцээд авсан. Усанд хүрч, хөвөх гэдэг байна шүү. Сүүлнээс нь бариад авсан чинь эргэж хараад намайг тоншоод авсан. Тэгэхээр нь нэг гараараа хөлнөөс нь, нөгөө гараараа хүзүүнээс нь барьж байгаад мушгичихсан. Хугарч байгаа хүзүүний чимээ надад тун их таашаал хүртээсэн дээ. Эрхэм ээ, хоол бэлэн боллоо. Ха ха.

Олзоо «отог» –тоо аваачсан. Гэхдээ цахлайны өдийг зулгааж, гэдэс дотрыг нь цэвэрлэхэсээ өмнө тоншуулсан шархаа йодолсон. Надад одоо халдвар авах л дутаад байж гэнэ. Шувууны хошуу үй түмэн нянтай шүү дээ.

Барих нь ч яахав барьчихсан. Гэтэл харамсалтай нь болгож чадаагүй. Давалгаанаар эрэг дээр шидэгдсэн нэг ч мөчир, нэг ч банз байдаггүйн дээр ганц завь байсан нь живчихсэн. Тэгэхээр түүхийгээр нь идэхээс өөр арга байсангүй. Ходоод гэдэс маань шувууны махыг нэн даруй буцааж гаргахыг хүслээ. Би ходоод гэдсээ ойлгож байсан ч зөвшөөрч чадахгүй байлаа. Тэгээд дотор муухайрахыг нь болих хүртэл уруу тоолж эхэлсэн. Ингэхээр зүгээр болчихоод байдаг юм.

Новш чинь миний шагайг хугалаахаа шахаад, бас гарыг минь тоншчихсон шүү. Хэрэв маргааш ахиад нэгийг барих юм бол нэлээд зовоох юм шүү. Энэ удаад ч яахав хурдан үхэх боломж олгочихлоо. Одоо ч гэсэн юм бичиж байхдаа эндээс доошоо харахад л элсэн дээр хэвтэх шувууны тасархай толгойг харж болж байна. Хар нүдэнд нь үхлийн манан татчихаад байхад л намайг даапаалаад байх шиг санагдаад байх юм.

Цахлайнд ер нь тархи гэж байдаг болов уу?

Байдаг бол идэж бодлог болов уу?

1-р сарын 29

Өнөөдөр ходоодны мухарт шидчих юм байдаггүй ээ. Нэг цахлай надаас холгүй хадны ирмэг дээр суусан ч намайг «чанх урдаас нь оновчтой дамжуулалт» өгч амжихаас өмнө нисээд явчихсан, ха ха. Сахал ургаад эхэллээ. Аймаар загатнаж байна. Хэрэв цахлай эргээд ирвэл барьж байгаад алахаасаа өмнө нүдийг нь ухааж авна даа.

Ний нуугүй хэлэхд би маш сайн мэс засалч байсан юм шүү. Муусан юмнууд л мэргэжлээрээ ажиллахыг минь хорьчихсон болохоос. Гэхдээ нээрээ, бүгд л үүнийг хийдэг байж нэг нь баригдмагц л гэв гэнэт ариун амьтад болчихдог, инээд хүрмээр шүү. Намайг ч ёстой нэг баллаж өгсөн дөө.

Дадлагын эмчийн дүрд тоглож байхдаа есөн шидийн адал явдалд орооцолдсоор залхаад сүүлдээ Парк Авенюд өөрийн гэсэн эмнэлэг нээсэн дээ. Надтай «мэргэжил нэгтэй» зарим юмнуудын адилаар баян аав, өндөр ивээн тэтгэчийн ачаар бус бүгдийг өөрийн гараар, өөрийн зүтгэлээр нээсэн юм шүү. Эмч хийх эрхгүй болох үед аав гуай ядуусын оршуулгын газар нойрсоод есөн жил болж байлаа. Эх гуай намайг лицензээ хураалгахаас жилийн өмнө өөд болчихсон.

Тун ч эвгүй байдалд орсон доо. Би Ист-сайдын долоо найман эмийн санч, хоёр том эм нийлүүлэгчээс гадна багаар бодож хориод бусад эмч нартай хамтран ажилладаг байлаа. Би тэдэн рүү өөрийнхөө үйлчлүүлэгчдийг, тэд над руу өөрсдийнхийгөө явуулна. Хагалгаа хийчихээд өвчин намдаахад шаардлагатай бүх эмийн жорыг нь бичээд өгчихнө. Хагалгаа болгон заавал шаардлагатай байгаагүй ч, өвчтөний зөвшөөрөлгүйгээр нэг ч хагалгаа хийгээгүй юм шүү. Бас миний бичсэн эмийн жорыг хараад «Надад ийм эм хэрэггүй» гэж хэлсэн нэг ч өвчтөн байгаагүй юм. Жишээлэхэд, 1970 онд хэдэн өвчтөндөө бамбай булчирхайн хагалгаа хийлээ гэж бодоход, тэд намайг зөвлөвөл өвчин намдаагч эмийг ахиад тав, эсвэл арван жилийн турш уудаг байсан юм. Заримдаа би үнэхээр тэг гэж зөвлөдөг байлаа. Тэгээд ч ингэдэг эмч нь би ганцаараа биш нь мэдээж. Цаашилбал, бага зэргийн мэс ажилбарын дараа өвчтөн нойрондоо муу болжээ гэж бодъё. Эсвэл тураах эм уусныхаа дараа хэт цочимтгой болж гээ. Тэгвэл энэ бүхнийг аргалах шиг амар юм байхгүй. Нэг хоёрын гурваа, гүйцээ. Хэрэв би тэдэнд хэрэгтэй юмыг нь өгөхгүй юм бол өөр эмчээс л очоод авчихна шүү дээ.

Тэгэж байтал татварын албаныхан дарамтлаад эхэлсэн, Лоуэнталийг. Муу ухныг дээ. Тэгээд таван жил хорьно гээд айлгаадахсан нь нөгөөх нь амиа авч үлдэх гээд арваад нэр хэлээд өгчихгүй юу. Тэд намайг нэг их удаан мөрдөж мөшгөөгүй ч бариад авах үед нь би таваас илүү жилээр сууж магадгүй болчихсон байсан. Гарын үсэгтэй жорын хоосон маягт зарахаас эхлээд хэд хэдэн хэрэг байсан. Тэр хоосон жорын маягтыг бодохоор инээд хүрээд байдаг юм. Тийм жижиг наймаа хийх ямар ч шаардлага байгаагүй мөртлөө сурсан зангаараа л зараад байсан байгаа юм даа. Сул мөнгөнөөс татгалзаж чадахгүй л байхгүй юу.

Тэгээд яахав би ганц хоёр хүн мэддэг байлаа. Ийш тийш нь чимээ тавьж байгаад хоёр гурван хүнийг чононуудад хаяж өгсөн дөө. Дан надад таалагддаггүй хүмүүсийг. Бүгдээрээ өөдгүй новшнууд байсан юм. Бурхан минь ямар их өлсөж байн аа.

1–р сарын 30

Өнөөдөр цахлай байдаггүй ээ. Жижиг наймаачид тэргэнцэр дээрээ «Өнөөдөр улаан лооль байхгүй» гээд биччихсэн явдаг шиг юм болж байна даа. Хурц хутгаа аваад цээжээ хүртэл усанд орж зогслоо. Халуун наран доор ийм байдлаар хөдөлгөөнгүй дөрвөн цаг зогсож үзэв. Хоёр ч удаа одоо унах нь уу даа гэж бодож байсан ч эвгүйцэнгүйт нь гайгүй болох хүртэл нь уруугаа тоолоод байсан. Ингэж зогсохдоо нэг ч загас олж харсангүй. Нэгийг ч шүү.

1-р сарын 31

Анхныхтайгаа адил аргаар бас нэг цахлай аллаа. Дэндүү өлсгөлөн байсан болохоор занаж байсан шигээ зовоох тэвчээр байсангүй. Гэдэс дотрыг нь цэвэрлэж байгаад идчихсэн. Дараа нь гэдэс дотроос нь хамаг сангасыг нь шахаж байгаад бас идчихсэн. Эргээд тэнхээ орж байгаагаа мэдрэх сонин байсан шүү. Би бүр бага зэрэг айгаад эхэлчихсэн байсныг хэлэх үү. Арлын төв хэсгийн мундаг том хадны сүүдэрт хэвтэж байхад хүмүүсийн дуу хоолой сонсогдох шиг болсон. Эх, эцэг, хуучин эхнэрийн дуу сонсогдоод. Хамгийн муухай нь Сайгонд надад героин зарсан нөгөө хужаагийн дуу байсан. Юу гэж байгаа нь мэдэгдэхгүй шулагнаад л, магадгүй хэлнийхээ талыг огтлуулчихсан байсан болохоор тэгдэг байсан биз.

«За алив, амсаад үз» гэж хий дуу нь хадаад. «Жаахан амсаад үзчих. Тэгвэл чи өлсөж байгаагаа ч мартана. Сайхан эд шүү...» Би харин энэ мэтийн заваан юм бүү хэл нойрсуулах эм ч ууж байгаагүй юм.

Лоуэнталь амиа хорлсон гэж би хэлж байгаагүй билүү? Муу ухныг дээ. Хуучин ажлынхаа өрөөнд боомилоод үхчихсэн. Тэгснээрээ олон хүнд буян үйлдсэн гэж би боддог.

Би эмчийнхээ лицензийг буцааж авахыг хүссэн юм. Ганц хоёр хүнтэй уулзсан чинь болно, гэхдээ их мөнгө хэрэгтэй гэгцгээсэн. Миний төсөөлж байснаас ч их мөнгө юм гэнэ. Миний сейфэнд дөчин мянган доллар байсан л даа. Тэгээд азаа үзэж эргэлдүүлэхээр шийддээ. Эргэлдүүлж байгаад хоёр, эсвэл бүр гурав нугалаад авна гэж.

Ронни Ханеллитэй уулзлаа. Бид хоёр коллежд хөл бөмбөг тоглодог байсан юм. Цагтаан би дүүд нь туслаж байсан юм. Роннийг хуулийн ангид сурдаг байсан гээд бод доо. Инээд хүрмээр юм. Бид хоёрын хамт өссөн гудамжинд мань хүнийг Зодоонч Ронни гэдэг байлаа. Мань хүн бөмбөг, цохиураар тоглодог бүх тоглоом, бас хоккейг шүүдэг гэж байгаа. Шүүлт нь таалагдахгүй бол дуугүй өнгөрөх, эсвэл ясаа тоолох гэсэн хоёр боломж л чамд бий. Пуэрторикочууд мань хүнийг Гоймон Ронни гэж дуудаг. Үүнд мань хүн дургүй ээ. Тэгээд ийм хүн сургуульд ороод, дараа нь хуулийн коллежд элсээд өмгөөлөгчийн шалгалтыг оромдож өгчихөөд манай тэнд, яг баарнаас өөдөөс харсан байранд контороо нээчихэж байгаа юм даа. Цагаан «Континенталь» даа суучихсан манай гудамжаар яаж явж байгаа нь нүдэнд харагдах шиг болдог юм. Тэндэхийнхээ хамгийн том буруу гарын бизнесмен.

Роннид надаар хийлгэх ажил байгааг нь би мэдэж байлаа. «Аюултай л ажил даа» гэж мань эр хэлсэн. «Гэхдээ чи хэзээд амиа аваад гарчихаж чадна. Дээр нь эвгүйтвэл чамайг хоёр хүнтэй танилцуулж өгнө өө. Нэг нь төрийн албан хаагч байгаа юм».

Дараа нь надад хоёр нэр хэллээ. Луг том биетэй Генри Ли Цу гэдэг хужаа, Солом Нго гэдэг вьетнам. Нго нь химич. Чамлахааргүй их хөлсөөр хужаагийнх нь нийлүүлсэн барааг нь шалгадаг. Хужаа нь байсхийгээд л элдэв янз болдог болохоор л тэр. Яадаг вэ гэхээр гялгар ууганд нь тальк, угаалтуур угаадаг нунтаг, цардуул хийгээд өгчихдөг байхгүй юу. Ингэж маяглаж байгад нэг өдөр амиа алдана даа гэж Ронни надад хэлж байсан.

2–р сарын 1

Онгоц нисч өнгөрлөө. Яг арал дээгүүр. Би хадан дээр гарч дохио өгөхийг оролдсон юм. Гэтэл хөл чулуун завсар орчихдог байгаа. Анхны шувууг алж байхдаа хөлөө хийчихдэг яг тэр чөтгөрийн завсарт. Тэгээд шагайгаа хугалчихсан. Давхар хугаралт. Яг л буудаж байгаа юм шиг дуу гарсан. Аймаар өвдсөн. Дуу алдахдаа тэнцвэрээ алдчихав. Тэнцвэрээ олох гэж нисэх нь үү гэлтэй гараа савчуулсан болов ч чадалгүй унаад, унахдаа толгойгоороо хад мөргөөд ухаан алдачихсан. Бүрэнхий болсон хойно л ухаан орлоо. Толгойны шархнаас бага зэрэг л цус гарсан байна лээ. Шагай харин машины дугуй шиг пэмбийж хавдасны дээр хамаг бие наранд аймаар түлэгдчихэж. Нар ахиад ганц цаг илүү туссан бол хамаг бие цэврүүтэх байсан байна шүү гэж.

Догонцсоор ийшээ ирээд бэмбэгнэтэл чичирсэн амьтан өвдөлт, арчаагүй байдалдаа бухимдаж шөнөжин уйлсан. Толгойн, баруун тал, чамархайн хэсэг дээрх шархаа ариутгаад чадлынхаа хэрээр сайн боочихсон. Арьсны өнгөц шарх бас миний бодож байгаагаар тархины бага зэргийн доргилт. Харин шагай... Хоёр, эсвэл бүр гурван ч газраа хугарснаас зайлахгүй.

Одоо яаж цахлайны араас гүйх болж байна аа?

«Каллас»–аас амьд үлдсэн хүмүүсийг хайж байгаа эрлийн онгоц заавал байх ёстой доо. Далайн давалгаа намайг онгоц живсэн газраас олон бээрийн хол аваачсан байж болох юм. Тэгвэл тэд ийшээ ирэхгүй ч байж болзошгүй.

Шагай ямар их өвдөж байна аа, бурхан минь гэж.

2–р сарын 2

Би аврах завьны живсэн газраас холгүйхэн, арлын урд хэсгийн эргийн дагуу тэмдэг өрөөд тавьчихлаа. Ингэх гэж хэд хэдэн удаа завсарлаж, сүүдэрт амарч байж бүтэн өдөр зарцууллаа. Амарсан мөртлөө л хоёр удаа ухаан алдсан. Би дийлэнхдээ шингэний дутагдлаас болж багцаагаар хорин фунт орчим жин алдаж. Гэхдээ одоо бол би эндээс, сууж байгаа газраасаа өдрийн турш бичсэн үсэгнүүдээ харж болж байна. Цагаан элсэн дээр хар чулуугаар «Туслаарай» гэж бичсэн. Үсэг бүр нь дөрвөн футын өндөртэй. Дараагийн онгоц намайг заавал анзаарч харна даа.

Гэхдээ дараагийн онгоц нь үүгээр нисвэл шүү дээ.

Хөл байнга өвдөх юм. Бүр ч илүү хавагнаад, хугарсан газар нь сэжиг бүхий толбо гараад ирчихэж. Толбо нь томроод байх шиг байна. Цамцаараа чанга барьж боохоор өвдөлт нь багар зэрэг намдах ч аймаар хүчтэй өвдөж байгаа болохоороо би унтах гэхээсээ илүү ухаан алдалтын байдалтай байх шиг байна.

Тайрах хэрэг гарч магадагүй талаар бодох боллоо.

2–р сарын 3

Шагай бүр ч илүү хавдаад толбоны хэмжээ ч томроод байна. Хагалгаа хийх хэрэгтэй болвол өөрийгөө чадна гэж бодож байгаа. Надад хурц хутгыг ариутгах чүдэнз бий, оёдлын иж бүрдлээс авсан утас зүү бий. Цамцыг боолт болгоод урчихна.

Бас надад хоёр кило өвчин намдаагч, өвчтөнүүддээ бичиж өгдөг байснаас арай өөр хэлбэрийн өвчин намдаагч байна. Гэхдээ миний өвчтөнүүдэд олддог байсан бол тэд ч энэ өвчин намдаагчийг хэрэглэх л байсан. Мөрийцсэн ч бэлэн байна. Тэр муусайн үсээ будсан чавганцууд эргээд сэргэх боломжтой л гэвэл дезодорант ч амьсгалахад бэлэн байгаа. Надад итгээрэй.

2-р сарын 4

Би хөлөө тайрахаар шийдлээ. Дөрвөн өдөр юу ч идсэнгүй. Энэ мэтээр цаг алдаад, өлсгөлөнгөөс болж шоконд ороод байвал хагалгааны үеэр ухаан алдаад цус алдсаар үхэж магадгүй. Харин би ямар ч муухай байсан хамаагүй амьдармаар байна. Анатомын хичээл дээр Мокриж бидэнд юу гэж ярьдаг байсныг би санаж байна. Бид түүнийг Хөгшин Мокки гэж дууддаг байлаа. Эрт оройгүй нэгэн цагт гэж тэр ярьдаг байлаа. – Анагаахын оюутан болгон сургалтынхаа явцад нэг асуулттай заавал тулгардаг. Хүн хэр хүчтэй гэмтлийн шокийг тэсч гарч чадах вэ? гээд анатомын хүснэгт дээрх элэг, бөөр, зүрх, дэлүү, гэдсийг ээлжлэн заангаа, хуруугаа чад хийн дуугаргадаг байсан. –Энэ асуултын хариу нь женгельменүүдээ гэж тэр яриагаа үргэлжлүүлнэ.– хариу нь үргэлж өөр нэгэн асуултанд тулдаг. Тэр нь хүн тэсч гарахыг хэр их хүсч байна вэ вэ? гэсэн асуулт.

Би хагалгааг амжилттай хийж чадна гэж бодож байна.

Үнэхээр тэгэж бодож байгаа. Зайлшгүй тулгарах зүйлийг бага ч гэсэн хойшлуулах гэсэндээ энэ бүхнийг бичиж байгаа байх гэж бодож байна. Гэхдээ би яаж яваад энд ирсэн тухайгаа гүйцэд яриагүй байгаагаа саналаа. Хагалгаа амжилтгүй болж магадгүй тул гүйцээсэн нь дээр байх. Энэ нэг их цаг авахгүй болохоор дуусахад үед нь хагалгаа хийж болохуйц гэгээтэй байна гэдэгт итгэлтэй байна. Тэгээд ч миний цаг одоо дөнгөж өглөөний ес болж байгааг зааж байна. Ха.

Сайгонд би жуулчны дүрээр нисч ирсэн. Хачин сонсогдож байна уу? Огтхон тийм биш юм шүү. Никсоны өдөөсөн дайныг үл харгалзан энэ орныг үзэх гэж ирдэг мянга мянган хүн байдаг. Хуучин машины сэг, азарган тахианы зодоон мэтийн зүйлийн үзэх гэж ирдэг хүмүүс байж л байдаг биз дээ.

Хужаа найз маань надад бараагаа өглөө. Нөгөөхийг нь Нгод аваачиж үзүүлэхэд, дээд зэргийн чанартай бараа байна гэж мэдэгдэв. Тэгээд дөрвөн сарын өмнө Ли Цу ээлжит удаагаа маягласных нь дараа эхнэр нь «Опель»–ийнхээ түлхүүрийг түлхээд дэлбэрсэн гэж надад хэлэв. Тэр явдлаас хойш элдэв маяг, янз ахиж ахиж гаргаагүй юм байх.

Би Сайгонд би гурван долоо хоног болсон юм. Намайг Сан–Францискод хүргэх ёстой байсан аяллын «Каллас» хөлөг онгоцны тасалбарыг захиалж авсан. Нэгдүгээр өрөө. Бараатайгаа онгоцонд ороход асуудал гарсангүй. Нго нь гаалийн хоёр ажилтанд хахууль өгчихсөн болохоор нөгөө хоёр нь миний ачааг үзсэн төдий дүр үзүүлээд өнгөрсөн. Бараа болохоор тэдний тоож ч хараагүй гялгар уутанд хэвгэж байса юм.

«Америкийн гаалиар гарах нь хавьгүй хэцүү юм болно доо» гэж Нго надад хэлсэн. «Гэхдээ энэ бол та нарын асуудал».

Би барааг америкийн гаалиар авч гарах гээгүй байлаа. Ронни Ханели нь нэгэн маш хүнд ажлыг гурван мянган доллараар гүйцэтгэж өгөх усанд шумбагчийг хөлсөлсөн юм. Би тэр хүнтэй Сан–Францискод «Сент–Режис отель» нэртэй хямдхан буудалд уулзах ёстой байв / миний тооцолсноор энэ уулзалт хоёр өдрийн өмнө болох ёстой байсан/. Төлөвлөгөө ёсоор

бол барааг ус нэвгэрдэггүй саванд хийнэ. Тэгээд саванд нь улаан будагтай уутанцар бас цаг бэхлэж өгөх ёстой байв. Хөлөг онгоцыг зогсоолд орохын өмнө савыг ус руу шидэх ёстой байсан юм.

Бэлэн мөнгөнд дуртайн дээр дараа нь илүү юм чалчаад байхааргүй сэргэлэн, эсвэл дүнхүүдүү өрөөний үйлчлэгч, туслах тогоочийг яг хайж байтал «Каллас» живчихсэн.

Яаж, яагаад гэдгийг нь бүү мэд. Давалга өндөр байсан ч онгоц зүгээр л байх шиг санагдаж байсан. Хорин гуравны оройн найман цагийн орчим тавцангийн доор, хаана ч юм бэ бүү мэд дэлбэрэлт болсон юм. Би энэ үед «Каллас»-ын гол тасалгаанд байж байсан бөгөөд онгоц шууд л зүүн тал руугаа хазайгаад эхэлсэн.

Хүмүүс орилолдон ийш тийш гүйлдэж эхэллээ. Бааран дахь лонхнууд тавиур дээрээсээ унан хага үсэрч байлаа. Доод талын тавцангаас нэг эр гуйвж дайвсаар гараад ирсэн. Цамц нь шатаад арьс нь улайчихсан. Аялал эхлэхийн өмнө өгсөн заварчилгааны дагуу өөр өөрийн харьяалагдах аврах завь руу очихыг чанга яриагчаар тушаалаа. Гэвч зорчигчид замбараагүй гүйлдсээр л... Зааварчилгаанд суух талаар бодсон хүн нь тун цөөн байсан юм чинь аргагүй л дээ. Харин би бол зүгээр нэг суугаагүй эртхэн шиг очоод хамгийн эхний эгнээнд суусан юм. Өөрийнхөө амь насанд шууд холбоотой юм болгонд би ямагт маш анхааралтай ханддаг.

Өрөөндөө орж героиноо хоёр хуваан халаасандаа хийсэн. Тэгээд аврах завь №8 – ийг зүглэн явлаа. Шатаар давцан дээр гарч байх зуур ахин хоёр дэлбэрэлт болж, онгоц бүр ч илүү хазайгаад эхэлсэн.

Давцан дээр ч жинхэнэ хөл толгой нь олдохгүй юм болж байлаа. Хүүхэд тэвэрсэн хүүхэн улам бүр хазайх тавцан дээгүүр муухай орилон хурд авсаар миний хажуугаар өнгөрсөн юм. Хүүхэн тэр эрчээрээ гүйсээр бариуланд тээглээд ус руу уначихсан. Агаар дээр хоёр бүтэн эргэчихээд гурав дахиа эргэж байхыг нь харж амжсан ч гүйцэд харж амжаагүй.

Нүүр, гар нь аймшигтай түлэгдсэн, тогоочийн цагаан хувцастай хүн замдаа таарсан юм болгоныг мөргөн «Надад туслаарай. Би юу ч харахгүй байна. Туслаарай. Би юу ч харахгүй» гэж орилоод л...

Үймээн сандраан нь багийн гишүүдээс зорчигчдод яг л халдварт өвчин шиг халдаж, бүгдийг хамарсан даа. Гэхдээ «Каллас» дээр эхний дэлбэрэлт гарснаас бүрэн живэх хүртэл ердөө хорь орчим минут л болсон гэдгийг хэлэх хэрэгтэй. Зарим аврах завийг орилж хашгичсан хүмүүс бүчэн авсан байхад, зарим хов хоосон. Миний суух ёстой 8 тоот завь онгоцны хазайсан талд байсан бөгөөд бараг хүнгүй шахуу байсан юм. Дэргэд нь үхлүүд цонхийсон, цоохор нүүртэй усан цэрэг бид хоёроос өөр хүн байгаагүй.

Усан цэрэг эр нүдээ аймшигтайгаар эргэлдүүлэн «Энэ муу чөтгөрийн тэвшийг усанд буулгая» гэсэн. «Хараал идсэн савангийн хайрцаг чинь яг одоо живэх нь».

Аврах завийг буулгах механизм нь уг нь бол тун хялбар зүйл байсан ч нөгөөх эр тэвдэж, тэнэгтэж байгаад өөрийнхөө талын бүх олсыг орооцолдуулчихдаг байгаа. Завь доошоо зургаан фут орчим нисээд унжчихлаа. Унжих унжихдаа хошуу нь бөгснөөсөө хоёр фут доогуур

унжчихсан.

Нөгөө усан цэргийг орилоод ирэхээр нь туслахаар дөхсөн юм. Тэтэл мань эр орооцолдоог өөрөө гаргаж чадсан ч гараа араанд хавчуулчихсан. Олс хэсэг зуур угаа савсуулж, арьсыг нь хуу татан алган дээгүүр нь гулгаад яах ийхийн зуургүй ус руу татагдаад орчихсон доо.

Би ч олсон шат буулгаж байгаад үтэр түргэн завиндаа суугаад унжлага олсноос нь салгаж авсан. Тэгээд сэлүүрдэж эхэлсэн дээ. Цагийн сайханд найзуудынхаа зусланд очихдоо зугаагаа гаргах гэж сэлүүрддэг байсан бол одоо амиа аврахын тулд сэлүүрдэж байлаа. «Каллас»-ын живэх газраас аль болох холдохгүй л юм бол эргүүлгэ нь намайг чирээд орно гэдгийг би сайн ойлгож байсан юм.

Онгоц ч таван минутын дараа усан дор далдарлаа. Харин би эргүүлэг үүсэх бүсээс нь хангалттай гарч амжаагүй байсан юм. Тэгээд ядаж ухралгүй нэг газраа тогтох гэж хамаг хүчээ шавхан сэлүүрдэхээс өөр аргагүй болсон. «Каллас» ч яах хийхэн зуургүй живсэн дээ. Онгоцны хошуун дээрх бариулаас барьсан хэдэн хүмүүс муухай орилолдоод л байсан. Яг л сүрэг сармагчин шиг.

Далайн давалгаа улам хүчээ авсан. Би нэг сэлүүрээ алдсан ч нөгөөхтэйгээ үлдсэн байлаа. Тэр шөнө яг л зүүд зэрэглээ шиг манараад өнгөрсөн дөө. Завиар дүүрэх усыг хутгаж байгаад сэлүүрээ авч галзуурсан мэт сэлүүрдээд, дараа нь ахиад л давалгаанд цохиулан усаар дүүрээд ирэхээр нь хутгаад...

Тэгэж байтал хорин дөрвөний өглөө, нар мандах үеэр давалгаа завийг түрж эхэлсэн. Завь ч урагшаа улаан галзуу хурдлаад. Энэ аймшигтай байсан ч бас давхар сэтгэл гижигдээд сайхан байсан. Гэнэт завины мод тачигнаад хугарч эхэлсэн ч живж амжаагүй байхад нь давалгаанаар энэ бөөн хадан дээр шидэгдэн амьд гарсан юм. Би хаана байгаагаа ч мэдэхгүй байна. Ямар ч баримжаа алга. Би ч баримжаалахдаа тааруу л даа. Ха ха.

Гэхдээ би хийх ёстойгоо мэдэж байна. Энэ бол сүүлчийн боломж ч гэлээ бүх юм бараг болчих байх гэж бодож байна. Өмнө нь би үргэлж мултардаг л байсан юм чинь. Орчин үеийн хиймэл хөл гэдэг чинь гайхамшигтай юм болсон гээд биз дээ? Тэгэхээр би өрөөсөн хөлтэйгээ ч сайхан амьдраад байж чадна.

Өөрийгөө төсөөлж явсан шигээ тийм мундаг хүн үү үгүй юу гэдгийг шалгах цаг ирлээ. Амжилт хүсье, залуу минь.

2-р сарын 5

Хийчихсэн шүү.

Өвдөлтийг яах вэ гэдэгт л хамгийн их санаа зовж байсан юм. Би өвдөлтийг тэсвэрлэн гарч чадна л даа. Гол нь бие ингэж сульдсан үед өлсгөлөн, өвдөлт хоёр хавсарвал дуусгаж амжихаасаа өмнө ухаан алдчих юм шиг санагдаад.

Гэхдээ героин аминд орсон шүү.

Нэг уутыг нь задлаж, хавтгай чулуун дээр мундаг том хоёр чимхийг асгаад хамраараа сорсон. Эхлээд зүүн талынхаа самсайгаар, дараа нь баруун талынхаараа. Хөлөөс толгой хүртэл нь бүх биеийг мэврүүлсэн хачин гайхамшигтай сэхүүнийг өөртөө оруулчих шиг л болсон. Дэвтэр дээр тэмдэглэлээ бичиж дууссан даруйдаа героин татсан юм. Тэгэхэд ес дөчин тав болж байсан. Тэгээд дараагийн удаа цагаа харсан чинь сүүдэр нэлээд цаашлаад, биеийн зарим хэсэг наранд гарчихсан байсан. Арван хоёр дөчин тав болж байсан. Тасарчихгүй юу. Ийм сайхан юм байдаг чинээ санаагүй юм байна. Яагаад өмнө нь тэгтлээ их үзэн ядаад байдаг байснаа ойлгохгүй юм. Өвдөлт, айдас, зовлон гээд бүх юм алга болоод зөвхөн тайван амирлангуй байдал.

Ийм байдалтайгаар л хагалгаагаа хийсэн дээ.

Гэсэн хэдий ч өвдөхийн хувьд бол өвдсөн. Ялангуяа хагалгааны эхэнд. Гэхдээ өвдөлтийг хөндлөнгөөс, яг л өөр хүний өвдөлт шиг харж байлаа. Тэгэхэд өвдөлт миний сэтгэлийг зовоохтойгоо адилаар бас татаж, сонирхол төрүүлж байсан. Энэ байдлыг ойлгож чадах хүн байна уу? Магадгүй өмнө нь морфинтой адил үйлчилгээтэй хүчтэй эм хэрэглэж үзсэн хүн бол ойлгож болох л юм. Энэ зүйл нь нь өвдөлтийг зүгээр нэг арилгачихдаггүй. Ухамсрыг өөрчилдөг. Бүх юм тод, ойлгомжтой болж ирнэ. Хүмүүс яагаад донтоод байдгийг нь би ойлгож байна аа. Гэхдээ «донтох» гэдэг ч юу байдгийг нь өөрсдөө мэдээж нэг ч удаа хэрэглэж байгаагүй хүмүүсийн зохиосон хэтрүүлэг байх.

Хагалгааны дунд үеэс өвдөлт эргээд мэдрэгдэж эхэлсэн. Ухаан алдахад тун ч дөхөж очсон доо. Цагаан нунтагтай задалсан уут руу санагалзсан байдлаар харц чулуудсан ч сэтгэлийнхээ тэнхээг дайчлан буруу харж чадсан. Ахиад нэмчихвэл ухаан алдаснаас ялгаагүй юм болж цус алдсаар үхнэ. Тэгээд зуугаас эхлэн урвуулан тоолж эхэлсэн.

Цус алдалт хамгийн том гай болж магадгүй байлаа. Мэс засалчийн хувьд үүнийг сайн ойлгож байсан л даа. Иймд илүү ганц ч дуслыг алдаж болохгүй. Эмнэлэгт бол мэс заслын үеэр өвчтөн цус алдаад эхэлвэл сэлгэх боломжтой. Харн надад ийм боломж байхгүй. Алдагдсан цусыг, хагалгаа дуусахад хөлөн доорх элсийг харлалат гоожсон цусыг бие махбодийн дотоод нөөцөөс бараг л нөхөөд сэлгэчих байх. Надад ямар ч төхөөрөмж, ямар ч багаж алга даа.

Хагалгаагаа арван хоёр дөчин тавд эхэлсэн. Нэг тавьд дуусгаад, дуусгасан даруйдаа героиноосоо ахиад нэг нэг тунг хүртчихсэн, өмнөхөөсөө хавьгүй илүү тунгаар. Тэгээд би өвдөлт огт байхгүй манантсан ертөнцөд умбаад, тэндээ бараг тав хүртэл байсан. Сэрэхэд нар

тэнгисийн хөх мандал дээгүүр алтан зам татуулаад жаргаж байсан. Амьдралдаа үүн шиг үзэсгэлэнтэй зүйлийг ер харж байсангүй... Миний бүх өвдөлт, шаналлын шан болсон өчүүхэн агшин... Жаргах нарны үзэсгэлэнг ханатлаа харахын тулд цагийн дараа ахиад бага зэргийг татсан.

Харанхуй болсоны дараа би

Би...

Байж байгаарай, байж байгаарай. Дөрвөн өдрийн турш юу ч идээгүй гэдгээ би чамд хэлээгүй билүү? Бас аажмаар шавхагдаж байгаа эрч хүчийг минь нөхөн сэргээхэд туслаж чадах цорын ганц зүйл нь миний биеийн нэг хэсэг байсан гэдгийг хэлээгүй билүү? Тэгээд ч зогсохгүй амьд үлдэх эсэх нь бидний амьд үлдэх хүсэл, тэмүүлээс шалтгаална гэж чамд дээрээс хойш ахин дахин давтаагүй билүү? Яахаас ч буцахгүй хүсэл тэмүүлээс шалтгаална гэж? Хэрэв чи энд, миний оронд байсан бол бас л тэгэх байсан гэж би өөрийгөө зөвтгөхгүй ээ. Нэгд гэвэл чиний мэс засалч байж таарах чинь юу л бол. За яах вэ эрхтэнийг яаж тайрахыг багцаалдаг байжээ гэж бодоход хагалгааг хийх гэж оромдохдоо цус алдаад үхэх байсан чинь гарцаагүй. За бүр больё, гэмтлийн шокийг, хагалгааг ч тэсээд гараад ирдэг юм аа гэхэд элдэв хорио цээр, ёс журмаар дүүрсэн толгойд чинь энэ тухай бодол хэзээ ч орж ирэхгүй байсан юм. За за энэ чухал биш. Энэ тухай хэн ч олж мэдэхгүй юм чинь. Энэ арлыг орхиж явахаасаа өмнө хийх миний хамгийн сүүлчийн зүйл бол энэ тэмдэглэлийг устгах.

Би маш болгоомжтой байсан юм шүү.

Идэхээсээ өмнө нөгөөхөө маш сайн угаасан.

2-р сарын 7

Мухарлаж үлдсэн хэсэг маш хүчтэй өвдөж, заримдаа бүр тэвчихийн аргагүй болж байсан. Гэхдээ миний бодлоор бол эдгэрэлт явагдаж эхэлснийг заадаг арьсан доорх загатналт нь илүү долоон доор. Оёдол хийсэн арьс, махны яагаад ч дарагдах боломжгүй, аймшигтай загатнааг тэвчиж дийлэхгүй нь гээд гонжигнодог байсан бүх өвчтөнүүдээ би дурсаж байлаа. Тэгэхэд би дотроо тэднийг хүнд баярлаж талархахын оронд нялцаганаад, янгуучлаад байдаг эрхийн тэнэгүүд гэж бодсон шигээ өөдөөс нь инээмсэглээд, маргааш арай гайгүй болно гэсэн утгатай юм хэлээд зогсож байдаг байлаа. Харин одоод бол тэднийг ойлгож байн аа. Хэд хэдэн удаа золтой л мухарынхаа боолтыг хуу татан хаяж байгаад зөөлөн шүүрхий маханд нь хуруу, хумсаа зоон өнгөрийг хуу татаад, цусаа элсэн дээгүүр гоожуулан маажчихаагүй шүү.

Яг ингэмээр санагдаад ирэхээр нь л би уруу тоолж, героин үнэрлээд байсан.

Хэр их героин татсаныг бүү мэд. Ямар ч л байсан хагалгаанаас хойших бараг дандаа л мод шиг хөшчихсөн амьтан хэвтээд л байсан. Өлсгөлөнг сайн дарах юм. Юм иддэг гэдгээ чүү чамай л санаж байна. Гэдсэнд, тэртээ хол л бага зэрэг хүржигнэж дуугарахаас өөр юу ч байхгүй. Ингэж дуугарахыг нь тоохгүй байгаад байж болохоор санагдаад байна. Гэхдээ тэгэж болохгүй ээ. Героин ямар ч илчлэггүй. Хэр тэнхээтэй байгаагаа шалгах гэж ийш тийш мөлхөж үзлээ. Миний тамир тэнхээ барагдаж байна.

Бурхан минь ахиад л ... биш юм шүү гэж би залбирах... гэхдээ ахиад нэг хагалгаа хэрэгтэй болж магадгүй юм.

/нэлээд хугацааны дараа/

Арал дээгүүр ахиад нэг онгоц нисч өнгөрлөө. Даанч дэндүү өндөрт ниссэн болохоор ямар ч хэрэг алга. Миний харсан зүйл гэвэл ардаа үлдээсэн утаа нь л байна. Гэхдээ л би гараа даллаад үзсэн. Даллаж, хашгирсан. Нисээд өнгөрснийх нь дараа би уйлчихсан.

Гэгээ бараг тасраад эргэн тойронд юу ч үзэгдэхгүй байна. Хоол. Би янз бүрийн хоолны талаар бодож байна. Сармхистай талх. Дун. Хавч. Хонины өөхтэй хавирга. Дээд зэргийн алим. Шарсан дэгдээхэй. Аймаар том бялуу, бас таваг дүүрэн гэрийн ванильтай зайрмаг. Загас бас хан борогцоотой утсан үхрийн мах. Сонгино. Шарсан төмстэй сонгины сүмс, удаан гэгч нь тамшаалан залгилах хүйтэн цай, франц аргаар шарсан мах.

Зуу, ерэн ес, ерэн найм, ерэн долоо, ерэн зургаа, ерэн тав, ерэн дөрөв...

Бурхан мин, бурхан минь, бурхан, бурхан...

2-р сарын 8

Өнөөдөр бас нэг цахлай хадны орой дээр суулаа. Аймаар том, тарган. Би хадны сүүдэрт, мухар хөлөө чулуун дээр тавьчихаад өөрийнхөө отог гэж нэрлэх болсон газраа сууж байсан юм. Цахлайг хармагц л шууд шүлс гоожоод эхэлсэн, Павловын нохой шиг. Би жаахан хүүхэд шиг шүлсээ гоожуулаад суугаад байсан. Яг л арчаагүй жаахан хүүхэд шиг.

Хангалттай том, гарт эвтэй хадны хэлтэрхий шилж авч байгаад цахлай руу мөлхлөө. Надад найдвар бараг л байгаагүй юм. Гэвч би үзээд алдах ёстой байлаа. Хэрэв барьдаг л юм бол, ийм тарган, лут шуувууг барьдаг л юм бол хоёр дахь хагалгаага нэлээд урт хугацаагаар хойшлуулж чадна. Тэгээд би мөлхлөө. Мухар маань чулуунд цохиулахад өвдөлт нь бүх биеэр минь давалгаална. Би тэр шувууг хэзээ л нэг нисээд явчих бол доо гэж хүлээж байсан.

Гэвч шувуухай нисдэггүй ээ. Цээжээ түхийлгэж байгаад жагсаалын үзлэг хийж байгаа нисэхийн генерал шиг л наашаа цаашаа чухал байдалтай алхалж гарсан. Үе үе жижигхэн, сэжиг хүрмээр нүдээрээ над руу харах болгонд нь хөдөлгөөнгүй хөшиж байгаад дахин алхалж эхлэх хүртэл нь уруу тоолоод байсан. Далавчаа дэвэх тоолонд нь зүрх зогсчих шиг болно. Миний шүлс зогсолтгүй асгарч байлаа. Яагаад ч нэмэргүй. Яг л жаахан хүүхэд шиг.

Хэр удаан гэтсэн юм бол бүү мэд. Магадгүй цаг, хоёр цаг болсон байх. Ойртох тусам зүрх хүчтэй цохилж, цахлай улам амттай харагдаад. Тэгсээр сүүлдээ энэ цахлай намайг даапаалж, чулуу шидэх зайнд дөхөнгүүт л нисээд явчих гэж байгаа юм шиг санагдаад. Хөл гар салаглаад эхэлсэн. Ам хув хуурай. Мухар маань аймшигтай өвдөхийг яана. Хар тамхины шарталт эхэлчихсэн юм биш байгаа гэсэн сэгжиг төрлөө. Ийм хурдан уу? Долоо хоног хүрэхтэй үгүйтэй хугацаанд л героин татсан шүү дээ би.

За энэ ч хамаагүй ээ. Надад хэрэгтэй юм чинь. Цаана нь зөндөө байгаа. Хэрэв дараа нь, Америкт очсон хойно эмчилгээ хийх хэрэг гарвал Калифорний хамгийн сайн эмнэлгийг сонгож авна даа, дуртайяа сонгож авна. Тэгэхээр одоо бол энэ асуудал биш. Тийм биз?

Чулуу шидэх зайнд мөлхөж хүрсэн ч шидсэнгүй. Онохгүй чинь баталгаатай юм байна гэсэн бодол гэнэт намайг зовоогоод эхэллээ. Бүр ч ойртох хэрэгтэй. Тэгээд яахав би чулуугаа атган, толгойгоо гэдийлгэж байгаад үргэлжүүлэн мөлхлөө. Миний үйлээ үзсэн биенээс хөлс гол мөрөн шиг л цуггалж байна. Чамд би хэлээгүй билүү, миний шүд өгөрөөд эхэлсэн гэж? Мухар сүсэгтэй байсан бол ч идсэн юмнаас л болж байна гэж бодох байсан байх даа. Идсэн юм нь болохоор...

Би зогтуслаа. Одоо бол өмнөх цахлайнуудад ч ойртож байгаагүйгээр ойртчихож. Тэгсэн атлаа л шидэх зориг хүрдэггүй. Хуруугаа цайтал нь чулуугаа атгасан мөртлөө л шидэж чадсангүй. Яагаад вэ гэвэл алдах л юм бол юу намайг хүлээж байгааг сайн мэдэж байсан юм.

Барааг дуусгасан ч хамаа алга. Би муусайн юмнуудаас бултаж чадна аа. Үлдсэн амьдралыхаа туршид ёстой сайхан, аз жаргалтай амьдарна. Уртаас урт үлдсэн амьдралынхаа туршид.

Тэр мууг хаднаас нисээгүй бол чулуугаа барин мөлхсөөр бүр тулж очих байсан байх гэж

бодож байна. Сэм мөлхөж очоод хоолойг нь боож алах байсан. Гэвч далавчаа ганцхан дэвээд л нисчихсэн. Би мухай орилон өвдгөн дээрээ өндийж байгаад хамаг чадлаараа чулуугаа шийдчихсэн. Тэгээд ... тэгээд оночихсон.

Шувуу хачин битүү дуу гаргаад хадны нөгөө тал руу унаад өгөв. Амандаа юм үглэн, инээд алдангаа мухраараа чулуу цохиж байгаа ч мэдрэхээ байгаад хадны орой дээр гарч, нөгөө тал руу нь бууж эхэллээ. Тэнцвэрээ алдаад толгойгоороо чулуу цохичихсон. Мундаг том овоосон ч гэлээ тухай үедээ л бол би анзаараагүй. Би шувууг оночихсон, одоо шувууг авах хэрэгтэй гэхээс өөр зүйлийг анзаарах, мэдрэх сөхөөгүй байлаа. Гайхамшигтай амжилт. Яг далавчинд нь.

Цахлай хугарсан далавчаа чирэн эрэг рүү сажилж байлаа. Гэдэс нь тэр чигтээ цус болчихож. Би араас нь мөлхөж чадах дээд хурдаа мөлхөж байсан ч шувуу надаас хурдан явж байлаа. Тахир дутуучуудын уралдаан. Ха ха. Бидний хоорондын зай богиноосоор бариад авчихвал авчих л байсан, миний хоёр гар хэрэггүй байсан бол. Миний гар надад ахиад хэрэг болно оо. Гараа гэмтээхгүйг зөндөө хичээсэн ч гэлээ далайг эрэг хүрэх үед миний алга цул шарх болчихсон. Дээр нь би цагаа халны ирмэгэнд цохиод хагалчихсан.

Цахлай муухай орилсоор усанд пүл хийн ороход нь би барьж авах гээд зүтгэлээ. Гэвч миний гарт сүүлнийнх нь хэсэг өд л үлдсэн. Дараа нь би унаад ус залгилж, золтой л живчихээгүй.

Гэвч би дахиад мөлхсөн. Бүр араас нь сэлэх гэж үзсэн. Мухрын маань боолт мултраад уначихсан. Живж эхэлсэн дээ. Ядарч туйлдаснаасаа болж чичирч салагалан, өвдөлтөөсөө болж галзуурахаа шахсан амьтан чөтгөрийн муу шувууг хараан зүхэж, уйлж, орилсоор эрэг дээр арай гэж гарч ирсэн. Муу шувуу харин эргээс бага багаар холдсоор усны мандал дээр удаан гэгч нь санжигнан хөвсөн. Харж тэвчилгүй, нэг мэдэхнээ эргээд ирээч гэж гуйгаад байсан уу яасан, сайн санахгүй байна. Гэхдээ тэнгисийн гүний хаданд тулж очих үед миний бодлоор цахлай үхчихсэн байсан байх.

Ямар шударга биш юм бэ.

Дараа нь отго дээрээ хүрэх гэж бараг бүтэн цаг болсон. Тэгээд героиноосоо ахиухан татсан ч гэлээ муу цахлайд уур хүрсээр л байсан. Тэртээ тэргүй баригдахгүй л байсан юм бол намайг тэгэж өдөх хэрэг юу байна аа? Яагаад эхнээсээ шууд нисээд явчихаагүй юм бэ?

2-р сарын 9

Би зүүн хөлөө тайраад мухрыг нь өмдөөрөө боочихлоо. Хагалгааны явцад шүлс тасралтгүй гоожсон. Гоожуулаад л байсан. Яг тэгэхэд, цахлайг хараад гоожуулж байсан шигээ. Яагаад ч зогсоох боломжгүй гоожуулсан. Тэгсэн атлаа би орой хүртэл хүлээж тэвчсэн шүү. Зуугаас тэг хүртэл уруугаар нь хорь, гучин ч удаа тоолчихов уу яав. Ха ха.

Тэгэж тоолохдоо...

Би байнга л хүйтэн шарсан мах, хүйтэн шарсан мах гэж амандаа үглээд л байсан, үглээд л байсан.

2-р сарын 11 /?/

Сүүлийн хоёр өдөр бороо орлоо. Хүчтэй салхитай. Дотор нь мөлхөөд орчихож болох нүх гаргах гэж төв хадны ойролцоох хэдэн том чулууг зайчилж дөнгөлөө. Нэг жижигхэн аалза олсон. Зугатаж амжихаас нь өмнө чимхэж барьж аваад... тэгээд идчихсэн. Ямар гоё амттай юм бэ. Шинэ мах. Дээр байгаа чулуунууд толгой дээрээс нураад ороод ирж магадгүй юм байна гэж бодлоо. Нурвал нурж л байг.

Шуурга дуустал нүхэндээ бүглээ. Магадгүй бороо хоёр биш гурван өдөр орсон байж болох юм. Эсвэл бүр ганцхан өдөр. Гэхдээ бороо дуустал хоёр удаа шөнө болсон шиг санагдаад байна. «Тас үсрэх» дуртай болчихоод байгаа, би. Өвдөлт ч тэр, загтнаа ч тэр мэдрэхгүй сайхан юм. Амьд гарна гэдгээ би мэдэж байн аа. Ийм их зовлонг хүн ямар ч хэрэггүй туулж гарна гэж юу байхав.

Хүүхэд байхдаа нэг сүмд очдог байлаа. Тэнд нь там, бузар нүглийн тухай цэцэрхэх дуртай нэг атигар лам мөргөл уншдаг байсан. Там, бузар нүглийн талаарх цэцэрхэх дуртайг нь яана гээ. Мань хүний бодлоор бол бузар нүглийг яаж ч цайруулах боломжгүй юм гэнэ. Тэгсэн чинь өчигдөр шөнө мань хүнийг зүүдэлдэг байгаа. Хар өмсгөл, живэр сахалтай Хэйли ламтан. Хуруугаа ёрдойлгож ирээд л «Чи ямар ичдэггүй юм бэ, Риччард Пинцетти гуай.... бузар нүгэл... чи хараагдсан шүү хүү минь... үеийн үед» гэх юм.

Би шоолоод инээчихсэн. Энэ там биш юм бол өөр юуг там гэх юм бэ? Тэгээд ч байж болох цорын ганц бузар нүгэл бол бууж өгөх.

Өдрийн хагасыг героинд мансуурч өнгөрүүлж байна. Үлдсэн хагаст нь мухар хөлнийхээ өвдөлт, загатнааг мэдэрдэг. Ядаж байхад чийгнээс болоод өвдөлт, загантаа нь улам нэмэгдэх юм.

Гэхдээ би бууж өгөхгүй ээ. Тангараглаж байна. Яасан ч бууж өгөхгүй. Энэ бүхэн ямар ч хэрэггүй байна гэж байх ёсгүй.

2–р сарын 12

Ахиад л нар гарлаа. Сайхан өдөр. Найз гэгддэг хэдэн юмнуудыг хөлдөж үхэх гээд сууж байгаа байх гэж найдаж байна.

Энэ арал дээр аз гээч юм байдаг бол өнөөдөр миний хувьд тун азтай байлаа. Тэнгэр муудсан үед халуураад байсан нь намдчих шиг боллоо. Нүхнээсээ мөлхөн гарч ирж байхдаа сульдаж, салаганасан амьтан байсан бол халуун элсэн дээр хоёр, гурван цаг хэвтэснийхээ дараа бараг л эргээд хүн болчих шиг боллоо.

Мөлхсөөр арлын урд хэсэгт очиж, шуурганаар эрэг дээр шидэгдсэн мод олсны дотор миний аврах завьны хэдэн банз байлаа. Банзнуудын зарим нь замганд хучигдчихсан байсан. Тэгэхээр нь хусч аваад идчихлээ. Амт гэж хэрэг алга. Нейлонон хөшиг идэж байгаа юм шиг л. Гэхдээ л энэ өдөр хамаагүй сайхан байна.

Олсон модоо хатаахын тулд эргээс аль болох хол чирж авчирлаа. Нордоггүй чүдэнзтэй сав надад одоо хүртэл байгаа шүү дээ. Намайг хайж байгаа бол дохионы түүдэг асаана. Үгүй бол дээр нь хоол хийж идэж болно. Харин одоо бол унтлаа, би.

2-р сарын 13

Хавчтай таарсан. Алаад бяцхан түүдэг асааж байгаад шараад идчихлээ. Энэ орой би бурханд бараг л итгэсэн шүү.

Тусламж хүссэн миний үсэгний дийлэнхийг нь давалгаа арилгачихсан байгааг өнөө өглөө л анзаарлаа. Шуурга чинь гурав хоногийн өмнө дууссан биз дээ? Энэ бүх өдрүүдэд би тэгтлээ манарчихсан байсан юм байхдаа? Байдлыг анхааралдаа авч, тунгаа багасгах хэрэгтэй юм байна. Тасарчихсан байх хооронд хөлөг онгоц хажуугаар өнгөрөөд явчихвал яана?

Би үсэгнүүдээ ахиад шинээр өрчихлөө. Ингэх гэж бүтэн өдөр зарцуулсан болохоор их ядарч байна. Өмнөх хавч баригдсан газраас хавч хайж үзсэн ч юу ч олсонгүй. Үсэг өрж байхдаа чулуунд гараа эсгэчихсэн болохоор ядарч байсан ч шархаа тэр даруй йодлож ариутгалаа. Би гараа арчлах хэрэгтэй. Яаж ч байсан гараа арчилна шүү.

Цахлай хадны орой дээр суулаа. Чулуу шидэх зайнд мөлхөж хүрэхээс өмнө нисээд явчихсан. Муу шувууг бодолдоо тамруу илгээлээ. Тэнд очоод үеийн үед Хэйли ламтаны нүдийг нь ухаж байг. Ха ха. Ха ха Ха.

2/17 (?)

Баруун хөлөө өвдөгнөөс нь доогуур огтлож авлаа. Гэхдээ цус их алдчихлаа.

Героин татаж байгаа ч өвдөлт нь нэмэгдээд байна. Надаас өөр хүн байсан бол ч гэмтлийн шокоос болоод аль хэдийн үхчихсэн байгаа даа. «Өвчтөн тэсч гарахыг хэр их хүсч байна вэ?» гэсэн асуултанд «Өвчтөн амьдрахыг хэр их хүсч байна вэ?» гэсэн асуултаар хариулахыг минь зөвшөөрнө биз дээ.

Гар салагалаад байна. Хоёр гар минь л болохгүй бол би өнгөрлөө л гэсэн үг. Намайг тэгэж хөөдөх эрх энэ хоёр гаранд байхгүй. Байх ч ёсгүй. Би энэ хоёрыг бүх насаараа л хамгаалж байсан. Арчилж байсан. Тэгэхээр намайг хөөдөх гэж оролдохгүй байсан нь дээр. Үгүй бол харамсана даа.

Одоохондоо ч яахав би өлсөөгүй байна. Завьнаас үлдсэн банзнуудын нэг нь дундуураа цуурчихаж. Нэг үзүүр нь хурц үзүүртэй. Би дээр нь шорлож байгаад ... хоолоо... Шүлс аймаар гоожиж байсан ч тэвчээр заагаад хүлээсэн. Тэгээд дараа нь нөгөө юу... махны тухай. Торон дээр том хэрчмээр нь шардаг байсан махны тухай бодож эхэлсэн. Уилл Хаммерсмитэд дээр нь бүтэн гахай шарж болох том тортой эдлэн газар Лонг Айлендэд байсан юм. Бид нар дүүрэн стаканаа дүүргэж барьчихаад саравчинд нь суунга мэс засал, гольф, эсвэл өөр зүйлсийн талаар ярилцдаг байсансан. Шарсан гахайны сайхан үнэр салхинд хөөгдөн хамар цоргиод л... Шарсан гахайн махны сайхан үнэр шүү, чөтгөр аваасай билээ.

2/- (?)

Нөгөө хөлөө өвдөг хүртэл нь тайрчихлаа. Өдөржин нойр хүрээд. «Эмч ээ, энэ хагалгааг заавал хийх ёстой байсан юм уу?» Ха ха. Гар хөгшин хүнийх шиг л салаглах юм. Үзэн ядаж байна энэ хоёр гарыг. Хумсан дороо цустай. Новшнуудыг дээ. Доторх нь нэвт харагддаг ходоодтой үзүүлэн эмнэлгийн коллежд байсныг санаж байна уу? Би яг л тийм болчихлоо. Харагдаад байх звйл алга. Нэг тиймэрхүү л. Миний хам Дом л голдуу ингэж ярьдаг байсныг санаж байна. Клубынхээ гонжоомыг өмсөчихсөн гудамжны булангаас эхлээд л бүжиглэсэн шиг ойртоод ирдэгсэн. Тэгээд за яасан Дом хамаа, хүүхэнтэйгээ хэр байв даа? гэж асууцгаана. Тэгэхээр Дом «Нэг тиймэрхүү» гэж хариулна. Дом хамаа гэж. Хуучин найз нарынхаа дунд, өөрийнхөө гудманд үлддэг байж дээ.

Гэхдээ би зөв эмчилгээ, сайн протезтэй бол дөнгөж төрсөн юм шиг л болно гэдэгтээ итгэлтэй байгаа. Ийшээ эргэж ирээд «Энд шүү дээ. Энд болсон юм» гэсэн шиг хүмүүст яриад байж байна даа. Хахаха

23-2(?) Үхсэн загас оллоо. Өмхий, илжирчихсэн. Тэгсэн ч гэлээ идчихсэн. Бөөлжмөөр байсан ч тэсээд гарсан. Би тэсч гарнаа. Эндэхийн үдэш мөн ч сайхан шүү.

2-р сар...

Хийж зүрхлэхгүй байгаа ч заавал хийх ёстой. Гэхдээ гуяны артерийн цусыг яаж тогтоодог билээ. Энэ түвшинд артери гэдэг чинь тоннель шиг л том байдаг шүү дээ.

Хийх ёстой. Ямар ч аргаар хамаагүй. Зүсэлт хийх шугамыг гуян дээрээ гаргачихлаа. Энэ хэсгээрээ бас ч гэж гайгүй махтай байна. Шугамыг яг энэ харандаагаараа гаргасан юм шүү.

Шүлс асгарахаа больдоггүй юм байх даа.

Би... өнөөдөр... түр амсхийх.... бүрэн эрхтэй шүү.... тун удахгүй.... босоод гарч...
«Макдональдс» орно доо... давтсан мах хоёр... сүмс... салат... давсалсан өргөст хэмх...
сонгино... талхтай...

Ня ня ня няяааа ня ня 2

Өнөөдөр усанд өөрийнхөө тусгалыг харлаа. Арьсаар бүрсэн гавлын яс. Ингэхэд би ер нь солирсон болов уу яасан бол? Сонин юм. Тийм л байх аа даа. Би эрэмдэг мангас болж хувирчээ. Жинхэнэ эрэмдэг мангас. Хавч. Тас үсэрсэн хавч. Нээрээ, цаадуул чинь өөрсдийгөө ингэж нэрлэдэг болчихсон байсан уу үгүй юу? Хөөе, залуу хөөрхий хавчинд ганц цент хайрлаач.

Хахахахаха

Хэн юу иднэ яг тийм болдог гэгцгээдэг. Үнэхээр тийм л юм бол би ОГТХОН Ч
ӨӨРЧЛӨГДСӨНГҮЙ. Бурхан минь гэмтлийн шок гэмтлийн шок. ГЭМТЛИЙН ШОК ГЭДЭГ
ЮМ ОГТ БАЙДАГГҮЙ ЮМ БАЙНА.

ХА

2/40?

Зүүдэндээ эцгийгээ үзлээ. Согтохоороо англиар ганц үг ч хэлж чадахаа байчихдаг юм. Хэлээд байх үг ч байхгүй байсан юм чинь дээ. Хөлдүү мал. Хөлдүү мал минь ээ, чиний гэрээс явахдаа мөн их баярлаж билээ би, аав гуай. Явна гэдгээ би мэдэж байсан юм. Тийм ч болохоор чамаас яваа биз дээ, айн? Гар дээрээ гарч явсан.

Гэвч хоёр гаранг минь өөр огтлох зүйл үлдсэнгүй дээ. Өчигдөр хоёр чихээ огтолчихсон.

баруун гараар хийсэн нүглийг зүүн гар угаадаг болохоор баруун гарын чинь юу хийж байгааг зүүн гарч чинь мэдэхгүй байж байг нэг хоёр гурав нэгэн зэрэг алхаад

хахахаха

Энэ гар байна уу, тэр гар байна уу ер нь ямар хамаа байна аа. мах бол хамгийн сайнаас сайн хоол шүү. Бурхан минь баярлалаа чамдаан. Чи минь бидэндээ үргэлж сайхан ханддаг шүү

хурууны амт, амт нь гэвэл яахав дээ л юм.

Эх сурвалж

Хөрвүүлсэн phiqstas

И-мэйл: phiqstas@gmail.com

Блог: kindlemn.blogspot.com

Орчуулсан [**Saxal**]

Форумд тавьсан [**cssmn**]

Вэб: [**<http://forum.asuultserver.com/viewtopic.php?f=84&t=173412>**]